



**ДУНГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧИЙН
ТОГТООЛ**

2015 оны 11 сарын 16 өдөр

Дугаар 70

Мандалговь


Хөрөнгө дахин үнэлж худалдах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 29 дүгээр зүйл, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 тоот тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”-ын 6.3.3 дах заалтуудыг үндэслэн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Адаацаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 62,943,020 /жаран хоёр сая есөн зуун дөчин гурван мянга хорь/ төгрөгийн анхны өртөгтэй, 27,346,945 /хорин долоон сая гурван зуун дөчин зургаан мянга есөн зуун дөчин тав/ төгрөгийн үлдэгдэл өртөгтэй Бага сургуулийн барилгын дуудлага худалдаагаар худалдах доод үнийг 10,000,000 /арван сая/ төгрөг болгон худалдахыг зөвшөөрсүгэй.

2. Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 07 сарын 01—ний өдрийн “Хөрөнгө данснаас хасах тухай” 42 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

3. Дуудлага худалдааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг Төрийн сангийн хөрөнгө борлуулсны орлогын 080000962 тоот дансанд төвлөрүүлэхийг Адаацаг сумын Засаг дарга Ж.Батхөлөг, Орон нутгийн өмчийн албаны дарга П.Очирбат нарт үүрэг болгосугай.

ДАРГА  С.БУДЖАВ